

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2025.05.21

Байгууллагын нэр:

Эрүүл мэндийн яам

Нэгжийн нэр:

Санхүү, эдийн засгийн бодлогын газар,
Хөрөнгө оруулалтын хэлтэс

Албан тушаалын нэр:

Барилга байгууламж, их засварын
хөрөнгө оруулалтын бодлого, хэрэгжилт
хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII
дугаар байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эрүүл мэндийн салбарын барилга байгууламж, их засварын хөрөнгө оруулалтын бодлогын төлөвлөлт, хяналт тавих, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Эрүүл мэндийн сайдын багцын барилга, байгууламж, их засварын хөрөнгө оруулалтын бодлого, хэрэгжүүлэх, зохицуулах, тайлагнах, мэргэжлийн арга зүйгээр хангах;
2. Барилга, байгууламж их засварын хөрөнгө оруулалтын цахим систем болон судалгаа, мэдээний сангийн үйл ажиллагааг зохицуулах;
3. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Эрүүл мэндийн сайдын багцын барилга, байгууламж, их засварын хөрөнгө оруулалтын бодлого, хэрэгжилт, зохицуулалт, тайлагналт, мэргэжлийн арга зүйгээр хангах;	Барилга барилга, их засварын хэрэгцээг тодорхойлж, дүн шинжилгээ, судалгаа хийгдсэн байна.	Г
	2.Барилга, их засварын ажлын зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлийг инженерийн байгууламжийн шинэ технологийн шийдэл, зах зээлийн боломж нөхцөлд нийцүүлэн боловсруулах ажлыг зохион байгуулах, зураг төсөлд магадлал хийлгэх баталгаажуулалт ажлыг зохион байгуулах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	1. Эрүүл мэндийн салбарын барилга байгууламж, их засварын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлийг хэрэгжүүлэх, хяналт тавих, санхүүжүүлэх;	Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүжилт олгогдсон байна.	Г, Х
	2. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагаа, гэрээний хэрэгжилтийн хяналт хийх.	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1. Салбарын санхүүгийн нэгдсэн тайланд барилга байгууламж, их засварын хөрөнгө оруулалтын мэдээ, мэдээллийг нэгтгүүлэх, тайлагнах;	Журмын дагуу тайлагнасан байна.	Г
	2. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, тайлагнах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г

	3. Хөрөнгө оруулалтын бүртгэл судалгаа хийх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэдээний сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, тайлагнах.	Журмын дагуу тайлагнасан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1. Хариуцсан асуудлын хүрээнд яамны болон төрийн жинхэнэ албан хаагчийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Хариуцсан асуудлын хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах	Г
	2.Төрийн аудитын байгууллагаас хөрөнгө оруулалтад гаргасан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжилтэд хяналт тавих, нэгтгэн тайлагнах;	Аудитын зөвлөмжийг хэрэгжилтийн хангасан байна.	Г
	3. Хариуцсан асуудлын хүрээнд ирсэн албан бичиг, өргөдөл, хүсэлтийг судалж, шийдвэрлэх, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж бүрдүүлж, хүлээлгэн өгөх;	Шийдвэрлэх үйл ажиллагаа хуульд нийцсэн, албан хэргийн стандартын дагуу хөтөлсөн байна.	Ш, Г
	4. Хариуцсан асуудлаарх салбар дундын хамтын ажиллагааг хангах, эрсдэлийн шалгуур үзүүлэлт боловсруулах, батлуулах.	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	
Мэргэжил	- архитектур, хот төлөвлөлт /0731/; - иргэний ба үйлдвэрийн барилга, байгууламж /0732/; - эдийн засаг /0311/; - санхүү /0412/.	
Мэргэшил		
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно	
	Дүн шинжилгээ хийх	- тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах, харьцуулан судлах; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - нэгжийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, үр дүнг тайлагнах; - бусад.

	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, үр дагаврыг хариуцах; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, хариуцах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг үлгэрлэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - багийн дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - бусад.
	Бусад	- төрийн албан хаагчийн ёс зүй, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - хүний эрхийн мэдрэмжтэй байх; - жендерийн эрх тэгш байдлын зарчмыг баримтлах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - архив, албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх; - англи хэл, бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, засах, дүгнэлт хийх чадвартай байх; - албан ажлын хүрээнд олж авсан төр, байгууллага, хувь хүний мэдээллийг нууцлах; - бусад.




IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Санхүү, эдийн засгийн бодлогын газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Бусад харилцах субъект

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам, агентлаг, бусад ытөрийн байгууллагын

	газар, хэлтэс, нэгжийн холбогдох албан хаагч; - Олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөр, төрийн бус байгууллагын холбогдох ажилтан; - Мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтан, иргэн.
V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
<u>Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА  /Б.БАТБАЯР/ 2025 оны дугаар сарын -ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ <u>Шийдвэрийн огноо:</u> 25.0521 <u>Дугаар:</u> 218 
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
<u>Байгууллагын нэр:</u> ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ <u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u> (тамга/тэмдэг)   /Д.ОЧИРБАТ/ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА 2025 оны дугаар сарын -ны өдөр	